



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026.01.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн (“ТТЗ” ХХК) үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 92.6%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
1	1	-	-	-	100.0%

2.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
26	14	12	-	-	82.3%

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:



Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
3	3	-	-	-	-	100.0

2.4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
16	13	2	1	-	-	87.5%

2.5. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	2	-	-	-	-	100%

2.6. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	94.2
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	100.0
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	59.9
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	58.3
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	75.0
Дүн		76.5

2.7. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
180	179	176	3	-	97.8

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.5, 2.1, 2.2, 4.4, 4.6, 5.1-5.4, 5.8, 5.9, 6.1, 6.2/

Хэрэгжилтийн байдал:

1) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд,



ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 92.6%-тай байна. /Хүснэгт 1/

2) Тавантолгой–Даланзадгад–Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах Техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг холбогдох шаардлага, шалгуурын түвшинд бүрэн боловсруулаагүйгээс шалтгаалан уг ажил удаашралтай хэрэгжиж байна.

3) “Богдхан төмөр зам” төслийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад төслийн хүрээний баримт материалуудыг хүлээлгэн өгөх ажлуудыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан боловч илүү санхүүжилт олгосон аж ахуйн нэгжүүд авлагаа барагдуулаагүй, үүнтэй холбоотойгоор хуулийн байгууллагад шилжүүлэх бэлтгэл ажил үргэлжилж байгаа нь уг арга хэмжээний хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна.

4) Батлагдсан төсвийн хүрээнд компанийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах ажил нь 2025 оны төсвийн тодотгол 09 дүгээр сард батлагдсаны улмаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дахин боловсруулж, 10 дугаар сард тодотгон батлуулсан. Үүний улмаас тендер шалгаруулалтыг товлосон хугацаанд бүрэн зохион байгуулах боломж бүрдээгүй, зарим тендерийн урилга олон нийтэд зарлагдсан бөгөөд худалдан авах ажиллагаа үргэлжилж байна.

5) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 26 арга хэмжээний хэрэгжилт 82.3% байна. Үүнээс 53.8% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 46.2% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

6) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Монгол улсын хөгжлийн бодлогод туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ	“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын төсөл, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж дуусна. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	60.0
Зорилт 2: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандартын шаардлагад нийцсэн аюулгүй ажлын байр, ажиллах орчныг бүрдүүлж ажилласан байна.	100.0
Зорилт 3: Байгаль орчны багц хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангана.	Төмөр замуудын БОННУ-нд тодотгол хийлгэж, батлуулсан байна.	50.0

Зорилт 4: Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.	Компанийн хөрөнгө оруулалт, эдийн засгийг үр ашигтай оновчтой төлөвлөж, төслүүдийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гаргасан байна.	87.1
Зорилт 5: Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.	Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана.	78.9
Зорилт 6: Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.	Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийн хангуулан ажилласан байна.	100.0

7) Тус байгууллагын 2025 оны II улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн 8 зөвлөмж өгсөн боловч Засгийн газрын 2025 оны “Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоол, Зам, тээврийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, мөн “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлэх арга хэмжээг авсан.

Дээрх зохион байгуулалтын өөрчлөлт, чиг үүрэг шилжилттэй холбогдуулан 2025 оны эхний хагас жилд өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг бүрэн хангах боломж хязгаарлагдсан байна.

8) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт-д дотоод аудит хийж, “ТТЗ” ХХК-ийн хэрэгжилт 10.0 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас явуулсан хяналт, шалгалтын дүнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 25.0 хувьтай байгаа бөгөөд дээрх хоёр арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 16.6 хувь байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ЗТЯ	20	2	-	10.0%
ЗГХХГ	24	6	-	25.0%
Нийт	48	8	-	16.6%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулах;
2. “Богдхан төмөр зам” төслийн хүрээнд илүү санхүүжилт олгогдсон аж ахуйн нэгжүүдийн барагдуулаагүй төлбөрийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн, санхүүгийн өр, төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг эрчимжүүлж, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж, холбогдох байгууллагад төслийн хүрээний баримт материалуудыг хүлээлгэн өгөх;
3. Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний бэлтгэл ажлыг заасан хугацаанд хэрэгжүүлж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зорилтот түвшинд хүргэж ажиллах;
4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайд болон ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцыг улирал тутам шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрэмд нийцүүлэн алдаагүй ирүүлж хэвших;
5. Гашуунсүхэйт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах;
6. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;
7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход анхаарч байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**
(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	1	1	100.0	20
2	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	26	26	82.3	20
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	3	3	100.0	20
4	Сайдын тушаалын хэрэгжилт	16	16	87.5	10
5	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	2	2	100.0	10
6	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	62	62	76.5	10
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	180	180	97.8	10
Нийт		290	290	92.6	